

НЭГ. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Бээжин Юни Констракшн Групп Монголиа” ХХК нь 1993 онд байгуулагдаад зам, гүүр, барилга байгууламжийн ажил гүйцэтгэж байна. Азийн хөгжлийн банкнаас Монгол улсад хэрэгжүүлж буй “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл (МОН3787/3788)”-ийн “Хөвсгөл дэд төсөл”-ийн хүрээнд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт хатуу хучилттай автозам ба авто зогсоолууд, явган аяллын жим, аялал жуулчлалын бүсийн нэвтрэх цэгүүд байгуулах төслийн ажлыг гүйцэтгэж байна.

Замын ажил 2022 оны 3-5-р сарын хооронд зураг төсөл дээр заасан цэгүүдийг олж сэргээн гадаслагаа хийж тэмдэгжүүлсэн. Карьеруудын булангийн цэгүүдийг тогтоогоод хөрс хуулалт хийсэн ба 37.9 км замынхаа чиглэлүүдийг сэргээн хөрс хуулалт, үндсэн барилгын ажил эхлэсэн бөгөөд хөрсөө нягтруулаад далангийн дүүргэлтийн ажил зураг төслийн дагуу тус тус хийгээд явж байна.

Тухайн төслийн гол зорилго нь: Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүсэд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбараас нуурын хүрээлэн буй орчны экосистемд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, аялал жуулчлалд зориулсан хатуу хучилттай автозам болон дэд бүтцийг байгуулах ажил юм.

Хөвсгөл нуурын баруун тал буюу Жанхайн даваа, Тойлогт чиглэлд ХНБЦГ-ын бүсэд байрлах жуулчны баазуудын 80% орчим нь нуурын зүүн тал буюу Ханх чиглэлд жуулчны баазуудын 20% орчим нь байрлан үйл ажиллагаа явуулдаг.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Агаар орчны талаар

Нөлөөллийн товч тодорхойлолт

Замд ашиглагдаж байгаа техникүүд, үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааны үед болон овоолго, карьерын догол, мөргөцөгүүд, тээврийн зам зэргээс салхины үйлчлэлээс тоос, шороо хийсч агаар орчныг бохирдуулдаг. 2022 оны 05-р сараас эхлэн хуурайшилттай үед тоосжилт бууруулах зорилгоор зам, талбайг усаар чийглэж ажилласан болно.

Шинж чанар: Хуурайшилт ихтэй ялангуяа хавар, намрын улиралд сул хөрс, шороо салхинд хийсэж ойр орчны агаарыг тоосоор бохирдуулдаг.

Эх үүсвэр: Замд ашиглагдаж байгаа карьер, тээврийн зам талбай, бутлуурын үйлдвэр

Бууруулсан арга зам: Карьер, тээврийн зам, бутлуурын үйлдвэрийн талбай зэргийг хуурайшилт ихтэй үед тогтмол усалж тоосыг дарж байна. Төсөл хэрэгжих орчимд олон салаа зам гаргахгүйгээр түр зам дээр анхааруулах тэмдэг тэмдэглэгээ тавьж нэг замаар иргэдийн зорчих аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Төсөл хэрэгжиж байгаа орчны дуу шуугиан, агаарын тоосжилтыг шинжилгээ судалгааг 4-р сар, 8-р сард тус тус хийлгэж ажилласан.

2.2. Нөлөөлөлд өртөх объект:

Замд ашиглагдаж байгаа карьер, тээврийн зам, хучилт хийж байгаа орчин, ажилчид, хөрс, ургамал

Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Гүйцэтгэл мян.төг	Хариуцсан албан тушаалтан
1.	Цаг агаарын хуурайшилттай үед тоосжилт дарах, тээврийн замыг чийглэх	2022 оны 7, 8, 9 сарууд	4 205.0	БО асуудал хариуцсан ажилтан
2.	Зам ангийн ажиллагсдад гэрэл ойлгогчтой хантааз, бээлий авч өгөх	5 сар	458.2	ХАБЭА-н хариуцсан ажилтан
3.	Агаар орчны дуу чимээ, тоосжилтод БО - ны Хэмжилзүйн төв лабораториор шинжилгээ хийлгэх	4, 8 сар	792.0	“Шүтээн байгаль” ХХК

2.2.1. Хөрсний эвдрэл, элэгдэл

Нөлөөллийн товч тодорхойлолт

Замын материал авч ашиглаж газрын хөрс, геологийн тогтоц эвдрэх, машин механизмын хөдөлгөөний улмаас элэгдэлд орох, тоос болон машин механизмын утаатай хамт хаягдах хорт хий, хүнд металл зэргээр орчны хөрс бохирдоно.

Нөлөөлөлд өртөх объект

Карьер орчны хөрс, ургамал, хүн, амьтан

Нөхөн сэргээлтийн ажил

№	Ажлын нэр	Хугацаа	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай, га	Зардал, мян.төг	Хариуцсан албан тушаалтан
1	Техникийн нөхөн сэргээлт	8, 9, 10 сарууд	7.5	Үйлдвэрлэлийн зардалд орсон болно	Ерөнхий инженер
2	Хөрсний итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэх	4, 8-р саруудад	37.9 км авто замын трассын дагуу, карьер, кемп	1255.1	“Шүтээн байгаль” ХХК

2.2.2. Ажиллагсдын нийгмийн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал

Нөлөөллийн товч тодорхойлолт

Замын тоног төхөөрөмж, техник дээр ажиллагсдын ихэнх нь тоосжилт, дуу чимээ, доргио чичиргээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй ерөнхийдөө хүрээлэн буй орчны физик, химийн бохирдолтой, хөдөлмөрийн хүндэвтэр нөхцөлд ажиллах нөхцөлтэй байгаа тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртөх, уушигны багтраа, мөгөөрсөн хоолойн өвчтэй болох магадлалтай.

Нөлөөллийн эх үүсвэр

- Орчны болон ажлын байрны тоосжилт
- Машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээ, доргио чичиргээ, тэнд гарч болох осол
- Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлт стандартын нормоос бага /температур, дулаан, чийгшил, гэрэлтүүлэг, чимээ шуугиан, доргио чичиргээ/

Нөлөөлөлд өртөх объект

Ажиллагсад

Нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Төлөвлөсөн зардал, мян.төг	Гүйцэтгэл, мян.төг	Хариуцсан албан тушаалтан
1	Зам ангид ажилладаг ажилчдыг гэрэл ойлгогчтой хантаазаар хангах, дохиочин ажиллуулах	05-р сард	13000.0 *160 хүн	2080.0	ХАБЭА хариуцсан ажилтан

2.3. Усан орчин хамгаалах арга хэмжээ.

Нөлөөллийн товч тодорхойлолт

Замын технологи, унд ахуйн хэрэгцээнд ашиглагдаж байгаа гадаргын усанд шатах тослох материалын асгаралт, ахуйн бохир усны нэвчилт зэргийн нөлөөгөөр төслийн орчмын гадаргын болон гүний ус бохирдох зэргээр усны чанар, нөөцөд сөрөг нөлөө учруулж болзошгүй. Нефтийн бүтээгдэхүүн болон шингэн хог хаягдал хаягдаагүй.

Эх үүсвэр: Хөвсгөл нуур, Эгийн гол

Бууруулсан арга зам: 2022 оны 4-р сард Хөвсгөл нуурын уснаас дээж авч “Инженер Геодиз” ХХК-ний итгэмжлэгдсэн лаборторид шинжлүүлсэн ба 8-р сард Хөвсгөл нуурын ус, Эгийн голын уснаас дээж авч SGS итгэмжлэгдсэн лаборторид шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүн стандартын хэмжээнд гарсан.

Нөлөөлөлд өртөх объект:

Газар доорхи ус, хүн ам, ургамал

Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Гүйцэтгэл мян.төг	Хариуцсан албан тушаалтан
1	Олон салаа замыг багасгах, зөвхөн 1 замаар зорчуулах зорилгоор Түр зам барьж тэмдэг, тэмдэглэгээ суурилуулсан.	2022 оны 5-р сард	6000.0	Ерөнхий инженер
2	Усны шинжилгээг Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны хэмжилзүйн төв лабораториор шинжилгээ хийлгэсэн	4, 8 сар	812.0	“Шүтээн байгаль” ХХК

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан 3 карьерт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

3.1. Техникийн нөхөн сэргээлт

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон бусад хууль тогтоолын дагуу уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын стандарт /MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008/-ын дагуу хийсэн.

Нөхөн сэргээлт-1. Хуучин хайрган хучилттай авто замд ашиглагдаад орхигдсон 2 метрийн өндөр эрэг үүссэн 1.5 га карьераас 1000 м³ замын материал авч ашигласан. 2022 оны 6-р сарын 22-ны өдөр “BUCC” LLC нь К-7 карьерийн техникийн нөхөн сэргээлтийг авто ковш автомашинаар налуулах, хэлбэржүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Авто ковш 1 ш, 5 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.



Нөхөн сэргээлт хийхээс өмнө



Огцом өндөр эргийг тэгшлэн хэлбэржүүлсний дараах байдал



Тэгшилж хэлбэршүүлсэн талбайг үржил шимт хөрсөөр хучив.


Нөхөн сэргээлт-2. К-8 карьер нь хуучин хайрган хучилттай авто замд ашиглагдаад орхигдсон 2.5-3 метрийн өндөр эгц эрэг үүссэн 3 га газраас 300 м³ замын материал аваад нутгийн иргэдийн эсэргүүцэл /2-3 үеэрээ нутаглаж байсан газар гэх мэт/-тэй тулгараад дахин ашиглахаа зогсоож хэлбэржүүлэн налууллаг үүсгээд техникийн нөхөн сэргээлт хийгээд орхисон байна.



К-8 карьерийн нөхөн сэргээгээгүй байх үе



Нутгийн иргэд эсэргүүцээд суулт хийж байгаа байдал



Хэлбэршүүлж налуулга үүсгээд, шимт хөрсийг дэвсгээд орхисон байгаа нь байгалийн жамаараа ургамал ургасан байдалтай байна.

Нөхөн сэргээлт-3. Жанхай давааны ард байрлах 2012-2013 онд одоогийн хайрган хучилттай авто замын барилгын ажилд ашиглаад, нөхөн сэргээлт хийгдээгүй замын хажуугийн ухмалын 2-3 га талбайн овоолгыг налуулан хэлбэржүүлэх чиглэлийг энэ оны 7-р сард БОАЖЯ-ны сайдтай хамтарсан ажлын хэсэг газар дээр нь очиж ажиллахдаа нөхөн сэргээж, тэгшлэн хэлбэржүүлэх чиглэл үүрэг өгсөний хүрээнд 9-р сард манай компанийн ажилчид авто ковш 2ш, экскавотар 2 ш, 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж хайрган хучилттай зогсоол болгон зассан болно.



Замын хажуугийн ухмалыг хайрган хучилттай зогсоол болгож засав.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажил: Манай компанийн зүгээс орон нутаг, нутгийн иргэдтэй нийгмийн хариуцлагын хүрээнд замын трассын зурагтай налж орж ирсэн 20 гаруй аж ахуй нэгж, айл өрх, иргэний хашааг трассаас 1-2 метр хойш нь зөөж, эвдэрч хэмхэрсэн хашааг нөхөн сайжруулж янзлаад газар дээр нь суулгаад хүлээлгэн өгсөн. Энэхүү ажилд 6-7 хүн жижиг оврын машин механизм ажилласан.



Хашааг шилжүүлэн суулгасан байгаа нь

ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус хайгуул судалгааны явцад 1 газраас нийт 2 дурсгал илэрч олдсон нь соёлын өв, археологийн нандин өв юм. Судалгааны үед эхний дурсгал нь Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн замын трассаас баруун зүгт 100 м зайд, хоёрдугаар дурсгал нь мөн замын трассаас баруун зүгт 280 м зайд тус тус илэрч тэмдэглэв.

Автозамын трасстай ойрхон тодорхойлогдсон 2 археологийн дурсгалуудыг туслах зам тавих, хүнд техникийн хөдөлгөөн зэргээс хамгаалах арга хэмжээ авсан.

Тухайлбал, эдгээр дурсгал буйг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ босгож байрлуулсан.

ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглаж төлөвлөгөө зохион ажиллаж байна.

Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулж ажилласан.

Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллаж байна.

Галын сараа, кемпийн аянга зайлуулагч газардуулга байрлуулсан.



Аюул ослын үед хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн бэлэн байдал



Аянга зайлуулагч зам ангийн кемпийн газар дээр хийсэн.

ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүнд хэрэггүй бүгдийг хог хаягдал гэнэ. Хүний амьдралын боломж нэмэгдэхийн хирээр хэрэглээ ихсэж хог хаягдлын хэмжээ өсдөг. Хатуу хог хаягдал нь хүрээлэн байгаа орчин /ус, агаар, хөрс/-д болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Аливаа хог хаягдлыг ялгах, цуглуулах, зайлуулах, цэвэрлэх, халдваргүйжүүлэх цогц арга хэмжээ нь хүрээлэн буй орчин, хүн амын эрүүл мэндийг хамгаалах ач холбогдолтой. Замын компани Хатгал тосгоны захирагчийн ажлын албатай хог хаягдлын гэрээг 1 жилийн хугацаатай байгуулан хамтран ажиллаж байна.

Зам ангиас гарах хатуу хог хаягдлыг хогын саванд цуглуулж, тосгоны хогийн цэгэнд зайлуулж байна. Замд хэрэглэгдэх техникээс гарах хатуу хог хаягдал болох машин техникийн сольсон эд анги, аккумулятор, төмрийн хаягдал зэргийг засварын газрын ойролцоо талбайд хурааж байгаад хоёрдогч түүхий эд цуглуулах цэгт нийлүүлнэ.

Ашиглах боломжгүй болсон резин дугуйг тусгай талбайд хурааж байна. Ашигласан тослох материалыг мөн адил төмөр торхонд төрөл төрлөөр нь ангилан цуглуулж байгаад хоёрдогч түүхий эдэд тушаадаг.

Сар бүрийн 25-ны өдрийн дотор багтаан Төрийн сангийн 100172100947 тоот дансанд тушааж байна.

Замын ажил явагдаж байх үед үүсэх хог хаягдлын гол эх үүсвэрүүд:

Хаягдлын ангилал	Анхдагч эх үүсвэр	Хог хаягдлын төрөл	Хог хаягдлыг цуглуулж, зайлуулсан нь
Ахуйн хог хаягдал	Гал тогоо, оршин суух байр	Цаас, баглаа боодол, хүнсний хаягдлууд, шил, сав, лааз, хуванцар, гялгар уут, зуухнаас гарах үнс	5 м * 3м хэмжээтэй хогны төмөр саванд цуглуулж, тосгоны хогийн цэгэнд 2 удаагийн ачилтаар зайлуулсан
Үйлдвэрийн техникийн хог хаягдал	Техникийн засварын цех, талбай, автогараж	Арчих давуун материал, техникийн маслын, агаарын, түлшний шүүрнүүд, аккумулятор, резин дугуй, ашиглах боломжгүй болсон сэлбэг хэрэгслүүд гэх мэт	Машин техникийн сольсон эд анги, төмрийн хаягдлыг талбайд хурааж байгаад хоёрдогч түүхий эд худалдан авдаг иргэдэд тушаасан. Хуучин дугуй талбайд хураалттай байгаа. Бусад хог хаягдлыг хогын төмөр саванд цуглуулж, тосгоны хогийн цэгэнд зайлуулсан байдаг.
Ашигласан тослох материал	Техникийн засварын цех, талбай	Хөдөлгүүрийн тос, хүч дамжуулах хэсгийн ТАП, гидрийн шингэн, товуд	Төрөл төрлөөр нь төмөр торхонд ангилан цуглуулж, хоёрдогч түүхий эдэд тушаасан
Бохир ус	Гал тогоо, оршин суух байр, халуун ус	Саарал ус	Тусгай цооногт нийлүүлж байна.

ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг замын ерөнхий инженер, байгаль орчны асуудал хариуцсан ажилтан нар хариуцсан гүйцэтгэж байна. 2022 онд 3 байршлын 7.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. Нөхөн сэргээлт хийсэн талбайг орон нутгийн аймаг, сумын захиргаанд танилуулж хүлээлгэн өгнө.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг Тогтвортой аялал жуучлалыг хөгжүүлэх төсөл (МОН3787/3788), ХНБЦГ, Алаг-Эрдэнэ сумын удирдлага, Хатгал тосгоны багийн Засаг дарга болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулсан. Санхүүжилтийг компани хариуцав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд компанийн нийт ажиллагсад оролцов. Төлөвлөгөөний гүйцэтгэлд компанийн ерөнхий инженер хатуу хяналт тавьж ажилласан.

2022 оны БОМТөлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн

№	Ажлын төрөл	Хийж гүйцэтгэсэн хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Хяналт тавьсан албан тушаалтан
1	Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулсан	2022 он 04-р сар	Сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	“Бээжин Юни-Констракшин групп Монголиа” ХХК-ний гүйцэтгэх захирал
2	“Шүтээн байгаль” ХХК-тай БОМТ хийх гэрээ байгуулсан.	2022 он 04 сар	Ерөнхий инженер	Гүйцэтгэх захирал
3	Хуурайшилттай үед зам, талбайг чийглэж ажилласан	5 - 9 сарын хооронд	БО хариуцсан ажилтан	Замын инженер
4	Ажиллагсдыг гэрэл ойлгогчтой хантааз, бээлийгээр хангасан.	Жилийн турш	ХАБЭА ажилтан	Замын инженер
5	Агаар, хөрс, усны шинжилгээг хийлгэсэн	4, 8-р сар	Мэргэжлийн компани	Шүтээнбайгаль ХХК-ний захирал
7	Техникийн нөхөн сэргээлтийн ажил хийсэн. 7.5 га	7 – 10 сард	Замын инженер	Ерөнхий инженер
8	Хог хаягдлыг цуглуулж, тосгоны хогын цэгт зайлуулсан.	5, 10-р сард	Замын инженер	Ерөнхий инженер
9	Техникийн сольсон эд анги, төмрийн хаягдлыг цуглуулж, хоёрдогч түүхий эдийг тушаасан.	9 сард	Замын инженер	Ерөнхий инженер
10	Нийт ажиллагсад Байгаль орчныг хамгаалах талаар сургалтанд хамруулсан	6-р сард	БО асуудал хариуцсан ажилтан	Ерөнхий инженер

НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн	Хэрэгжилтийг хянуулах	БОМТ	2022.10	Аймгийн БОАЖГ газар
Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Хэрэгжилтийг хянуулах	БОМТ	2022.10	Аймгийн БОАЖГ газар
Орон нутагт /тухайн төсөл хэрэгжих бүс нутагт байгаа хүмүүс/ тайлагнах	Тайлангийн танилцуулга	БОМТ	2022.10	Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон
Орон нутгийн засаг захиргаа	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	2022.11	Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон
Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	2022.11	Аймгийн БОАЖГ газар

ЕС. ДҮГНЭЛТ

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулан хэрэгжүүлсэн.

Замын ажил 2022 оны 3-5-р сарын хооронд зураг төсөл дээр заасан цэгүүдийг олж сэргээн гадаслагаа хийж тэмдэгжүүлсэн. Карьеруудын булангийн цэгүүдийг тогтоогоод хөрс хуулалт хийсэн ба 37.9 км замынхаа чиглэлүүдийг сэргээн хөрс хуулалт, үндсэн барилгын ажил эхлэсэн бөгөөд хөрсөө нягтруулаад далангийн дүүргэлтийн ажил зураг төслийн дагуу тус тус хийгээд явж байна. Төслийн бэлтгэл ажилтай зэрэгцэн мэргэжлийн компани “Шүтээн байгаль” ХХК-ний экспертүүд төслийн талбай дээр 2 хоног ажиллаж агаар, ус, хөрсний дээж шинжилгээ авсан. Замын ажилчид чиг чиглэлийнхээ дагуу ажлуудаа гүйцэтгэж 2022 оны БОМТ-н дээр тусгасан ажлуудаа сайн хийж гүйцэтгэсэн байна. Энэ онд 3 карьерт техникийн нөхөн сэргээлт хийсэн.

2022 оны Орчны хяналт шинжилгээ мониторингийн ээлжит ажлаа 8-р сард “Шүтээн байгаль” ХХК-ний экспертүүд газар дээр нь очиж Агаар, ус, хөрс, ургамлын дээж авч мэргэжлийн итгэмжлэгдсэн лаборторид шинжилгээ хийлгүүлсэн. Шинжилгээний дүнгүүдээс харахад стандарт хэмжээнээс хэтрээгүй стандарт хэмжээнд байсан. Тус компани Алаг-Эрдэнэ сумын Засаг даргатай хог хаягдлын гэрээ, Эгийн голын усны сав газартай ус ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна.

АРАВ. ХАВСРАЛТ

Төсөл хэрэгжих талбайн агаарын өнөөгийн төлөв байдал

Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн мэргэжилтэн багаж тоног төхөөрөмжтэй төслийн талбай дээр 2022 оны 4-р сарын 12-14-ний өдөр урьдчилан төлөвлөсөн хээрийн судалгааны маршрутын дагуу агаар, дуу шуугиан 12 байршилд хэмжилт авлаа. /Шинжилгээний үр дүнг доорхи хүснэгтээр үзүүлэв./

Хүснэгт- 1. Үр дүн

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	N 50 ⁰ 26 ¹ 48.90 ^{II} , E 100 ⁰ 8 ¹ 55.08 ^{II}	IV/12	16:15	0.012	0.019	0.055	54
2	N 50 ⁰ 27 ¹ 44.87 ^{II} , E 100 ⁰ 6 ¹ 51.28 ^{II}	IV/12	16:45	0.009	0.020	0.060	64
3	N 50 ⁰ 25 ¹ 28.47 ^{II} , E 100 ⁰ 8 ¹ 46.77 ^{II}	IV/12	17:15	0.011	0.025	0.052	50
4	N 50 ⁰ 28 ¹ 4.62 ^{II} , E 100 ⁰ 9 ¹ 13.99 ^{II}	IV/12	17:45	0.007	0.018	0.035	42
5	N 50 ⁰ 29 ¹ 47.51 ^{II} , E 100 ⁰ 9 ¹ 45.53 ^{II}	IV/12	18:10	0.010	0.022	0.047	40
6	N 50 ⁰ 28 ¹ 28.62 ^{II} , E 100 ⁰ 6 ¹ 49.39 ^{II}	IV/12	18:50	0.013	0.025	0.057	35
7	N 50 ⁰ 28 ¹ 48.35 ^{II} , E 100 ⁰ 6 ¹ 52.13 ^{II}	IV/12	19:05	0.015	0.030	0.075	40
8	N 50 ⁰ 29 ¹ 15.40 ^{II} , E 100 ⁰ 6 ¹ 53.59 ^{II}	IV/12	19:30	0.012	0.035	0.045	30
9	N 50 ⁰ 39 ¹ 1.87 ^{II} , E 100 ⁰ 4 ¹ 46.77 ^{II}	IV/13	09:50	0.013	0.027	0.060	40
10	N 50 ⁰ 29 ¹ 47.51 ^{II} , E 100 ⁰ 6 ¹ 51.72 ^{II}	IV/13	10:00	0.009	0.028	0.083	30
11	N 50 ⁰ 32 ¹ 40.48 ^{II} , E 100 ⁰ 6 ¹ 5.64 ^{II}	IV/13	11:05	0.008	0.019	0.068	35
12	N 50 ⁰ 30 ¹ 25.94 ^{II} , E 100 ⁰ 6 ¹ 32.78 ^{II}	IV/13	11:35	0.015	0.036	0.047	40
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээний дүнгээс үзэхэд төслийн талбайн агаар, дуу шуугианы хэмжилтийн дүн стандарт хэмжээнээс даваагүй буюу стандарт хэмжээнээс нь бага хэвийн байна.



Авто замын трассын дагуух дээжлэлт /агаар, дуу шуугиан/

ГОЛОМТ БАНК GOLMOT BANK		ТӨЛБӨРИЙН БАРИМТ / APPLICATION FOR REMITTANCE	
Он сар өдөр 2022 / 4 / 29	Дүн / Amount =458,000.00= Мөнгөний нэгж / Currency <input checked="" type="checkbox"/> MNT <input type="checkbox"/> USD <input type="checkbox"/> Бусад	Үсгээр / In words (Дөрвөн зуун жаран найман мянган төгрөг)	
ХЭНЭЭС / FROM	Дансны нэр / Account name ШҮТЭЭН БАЙГАЛЬ ХХК	Төлбөрийн зориулалт / Details of payment ШҮТЭЭН БАЙГАЛЬ ХХК ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР РД	
	Дансны дугаар / Account No IBAN: MN19001500 1 4 1 0 0 1 4 6 3 8	5789958	
ХЭНД / TO	Банкны нэр / Bank name ТЭРИЙН САН	Гарын үсэг / Signature	Тамга / Stamp
	Дансны нэр / Account name БОХЗТ ЛАБОРАТОРИ	1st <i>[Signature]</i>	
	Дансны дугаар / Account No IBAN: 1 0 0 9 0 0 0 1 3 0 1 7	2nd <i>[Signature]</i>	
ЗӨВХӨН БАНКНЫ ХЭРЭГЦЭЭНД / FOR BANK USE ONLY		ТЭМДЭГЛЭЛ / NOTE:	
ХҮА / TELLER		Шинжлүүлэх данс <i>1110014030</i>	
Ханасан / Verified by		Хүлээн авах данс <i>100900013017</i>	
Он / сар / өдөр	<i>2022 / 04 / 29</i>	Хүлээн авах дансны нэр <i>БОХЗТ ЛАБОРАТОРИ</i>	
	<i>19 40 00</i>	Хүлээн авагчийн Банк <i>Төрийн сан</i>	
		Мөнгөн дүн <i>458000</i>	

БОХЗТЛабораториар хийлгэсэн шинжилгээний төлбөрийн баримт

1.3 Гадаргын болон газар доорх ус

2022 оны 4-р сарын 14-нд Хөвсгөл нуурын уснаас /50⁰ 37¹ 50.86^{II}, 111⁰ 47¹ 47.84^{II}/ дээж авч “Инженер геодез” ХХК-ний итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэсэн болно.

Хүснэгт- 2. Хөвсгөл нуурын усны химийн шинжилгээний тодорхойлолт

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг/л	Мг/экв	Мг-экв%,		мг/л	Мг/экв	%, мг-экв/л
Cl	17.73	0.50	28.45	Na ⁺ +K ⁺	16.75	0.73	41.48
SO ₄ ²⁻	6.15	0.13	7.29	NH ₄ ⁺	0.20	0.01	0.63
NO ₃ ⁻	1.72	0.03	1.58	Ca ²⁺	14.03	0.70	39.88
NO ₂ ⁻	0.01	0.00	0.01	Mg ²⁺	3.65	0.30	17.09
CO ₃ ²⁻	6.00	0.10	5.70	Fe ²⁺	0.30	0.02	0.91
HCO ₃ ⁻	61.02	1.00	56.97	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	92.63	1.76	100.00	Дүн	34.92	1.76	100.00

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 97.0 мг/дм³
 Анион катионуудын нийлбэр: 127.55 мг/дм³
 Ерөнхий хатуулаг: 1.00 мг-экв/дм³ рН: 8.62
 Исэлдэх чанар 3.84 мг/л
 Физик шинж чанар:
 Тунгалаг: 30 см Үнэр: үгүй Булинггар: тунгалаг
 Шүүгдэсний өнгө: Өнгөгүй Амт: үгүй

Усны давсны химийн найрлагын томъёо: $M_{104.0} \text{ мг/л} = \frac{HCO_3^- 56 Cl 28}{Na+K 41 Ca 39}$

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэй, маш зөөлөн ус байна. Шинжилгээ хийсэн арга стандарт: (MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)

2022.05.17 ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР № 25 УБЕХ маягт №БТ-2

Төлөгч: “ШҮТЭЭН БАЙГАЛЬ” ХХК

		Дебет		Дүн
Төлөгчийн:	ГОЛОМТ РД: 3789958	банк	код	Дансны № 1410014638
				198 000- 00
Хүлээн авагч:	Инженер Геодез ХХК РД:2635003			Кредит
Хүлээн авагчийн:	ГОЛОМТ банк	банк	код	2205021017
Мөнгөний дүн /усгээр, тоогоор/ Нэг зуун ерөн найман мянган төгрөг 00 мөнгө				
Төлбөрийн зориулалт: Усны шинжилгээний төлбөр				Гүйлгээний утга
				Төлбөрийн зориулалт

Дарга *М.Сүрэншатар*
 Нягт *А.Зурагч*

17 АХУ 2022

Хөвсгөл нуурийн уснаас дээж авч шинжлүүлсэн төлбөрийн баримт

1.4 Хөрсний судалгааны арга зүй

Дээрх судалгааны талбайд болон ойролцоох газрын судалгааны түүхтэй танилцах, талбай тус бүрийн байршлын талаарх анхан шатны зураг бэлдэх, агаар сансрын зургийг газарзүйн холболтонд оруулж, хэвлэлийн эх бэлдэх, хээрийн судалгаанд шаардагдах багаж хэрэгсэл, эд зүйлсээ бэлтгэх. Мөн холбогдох арга, аргачлалтай танилцаж хээрийн судалгаа болон боловсруулалтын ажилдаа ашигласан

А) Хөрсний хээрийн судалгааны арга зүй

Тус судалгааны зорилго нь Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ, Ханх сумдын нутаг дэвсгэрт орших тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл (МОН3787/3788)-ийн хүрээнд хийгдэх 37.9 км хатуу хучилттай зам баригдах газрын хөрсний төлөв байдал, шинж чанарыг тодорхойлох юм. Хөрсний хээрийн судалгааг 2022 оны 4-р сарын 13-14-ний өдөр урьдчилан төлөвлөсөн хээрийн судалгааны маршрутын дагуу явж хөрсний төрөл, газрын гадаргын ялгаатай байдал болон хөрсний эвдрэлд орсон байдлыг харгалзан үзэж ландшафт бүрт хөрсний зүсэлт бичиглэл хийх, GPS-ийн хэмжилт авах, хөрсний дээж авах ажлуудыг гүйцэтгэсэн. Хөрсний дээжинд морфологи болон зүсэлтийн бичиглэл хийж, лабораторын задлан шинжилгээнд зориулан хөрсний физик, хими шинж чанарын 3 дээж, бохирдол, эвдрэлийн 5 ширхэг дээж авлаа.

Хүснэгт- 3. Хөрсний дээжлэлт

Зүсэлт	Газрын нэр	Уртраг				Өргөрөг			
		Град	Мин	Сек	Х	Град	Мин	Сек	Ү
1	Замын эхлэл	100	8	55.09	100.149	50	25	48.9	50.430
2	2-р цэг	100	6	51.29	100.114	50	27	44.86	50.462
3	Карьер-1	100	8	46.77	100.146	50	25	28.47	50.425
4	5.5 км замын дунд хэсэг	100	9	13.99	100.154	50	28	4.62	50.468
5	5.5 км замын төгсгөл	100	9	45.53	100.163	50	29	47.51	50.497
6	Карьер 2	100	6	49.39	100.114	50	28	28.62	50.475
7	Кемп-1	100	6	52.13	100.114	50	28	48.35	50.480
8	Карьер-3	100	6	53.59	100.115	50	29	15.4	50.488
10	32.5 км замын төгсгөл	100	17	0.15	100.283	50	39	1.87	50.651
11	Карьер-4	100	6	51.72	100.114	50	33	54.2	50.565
12	Кемп-2	100	6	5.64	100.102	50	32	40.48	50.545
13	Хуучин ашиглаж байсан карьер	100	6	32.72	100.109	50	30	25.94	50.507



Зураг- 1. Хөрсөн бүрхэвчийн дээжлэлт хийсэн газрууд



Хөрсний өнгөн үеийн дээжлэлт хийж буй байдал

21/22, 11:30 AM

Бүртгэгдсэн

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт


EBARIMT.MN

ТӨЛБӨРИЙН БАРИМТ

Огноо: 2022-04-21
Худалдан авагчийн:
ТТД: 5789958
НЭР: ШҮТЭЭН БАЙГАЛЬ
Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 15-р
хороо, 5а, 2б
Утас:

ДДТД: 000002635003000220421000001829013
Борлуулагчийн :
ТТД: 2635003
НЭР: ИНЖЕНЕРГЕОДЕЗИ
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 6-р хороо, энхтайваны
эргэн чөлөө, 1-р давхар, А корпус
Утас: 77278899, 77278899, 99095839
Банжны нэр: Голомт банк
Банжны дансны дугаар: 2205021017

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Хөрсний гүний тогтоцын судалгаа	8342100	ш	1.00	730,400.00	730,400.00
Бараа, ажил үйлчилгээний үнэ:						664,000.00
Нэмэгдсэн өртгийн албан татвар:						86,400.00
Нийслэл хотын албан татвар:						0.00
Нийт дүн:						730,400.00



Тамга

Хүлээн авсан: /...../
(гарын үсэг) (нэр)

Хүлээлгэн өгсөн: /...../
(гарын үсэг) (нэр)

Хөрсний агро хими, хүнд металлын шинжилгээ хийлгүүлсэн төлбөрийн баримт

Төсөл хэрэгжих талбайн агаарын өнөөгийн төлөв байдал

Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн мэргэжилтэн багаж тоног төхөөрөмжтэй төслийн талбай дээр 2022 оны 8-р сарын 26-29-ний өдөр урьдчилан төлөвлөсөн хээрийн судалгааны маршрутын дагуу агаар, дуу шуугиан 8 байршилд хэмжилт авлаа. */Лабораторийн төлбөрийн баримтыг дор үзүүлэв/.*

Шинжилгээний дүнгээс үзэхэд төслийн талбайн агаар, дуу шуугианы хэмжилтийн дүн стандарт хэмжээнээс даваагүй буюу стандарт хэмжээнээс нь бага хэвийн байна.



1- р цэг бутлуурын үйлдвэр завод /агаар, дуу шуугиан, хөрс, ургамал/



2- р цэг Хатгал - Хүзүүвчийн шил чиглэлийн 5.5 км авто замын эхлэл /агаар, дуу шуугиан, хөрс, ургамал/



3- р цэг Хатгал - Хүзүүвчийн шил чиглэлийн 5.5 км авто замын дунд хэсэг /агаар, дуу шуугиан, хөрс, ургамал/



4-р цэг Хатгал - Хүзүүвчийн шил чиглэлийн 5.5 км авто замын төгсгөл хэсэг /агаар, дуу шуугиан, хөрс, ургамал/



5-р цэг 2.2 км авто замын трассын дагуух дээжлэлт /агаар, дуу шуугиан, хөрс, ургамал/



6-р цэг Замд ашиглагдаж карьер-2. /агаар, дуу шуугиан, хөрс, ургамал/



7-р цэг Ажилчдын кемп-1. /агаар, дуу шуугиан, хөрс, ургамал/



8-р цэг Замд ашиглагдаж карьер-3. /агаар, дуу шуугиан, хөрс, ургамал

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР № 28

2022.09.06
№БТ-2

УБЕХ мангт

Төлөөгч: “ШҮТЭЭН БАЙГАЛЬ” ХХК

		Дебет		Дүн
Төлөөгчийн:	ГОЛОМТ	РД: 5789958	банк код	Дансны № 1410014638
Хүлээн авагч:	БОХЭТ Лаборатори РД:5059313			324 000-00
Хүлээн авагчийн:	ТӨРИЙН САН банк		банк код	Кредит 100900013017
Мөнгөний дүн /үсгээр, тавооор/ Гурван зуун хорин дөрвөн мянган төгрөг 00 монго				
Төлбөрийн зориулалт Агаарын шинжилгээний төлбөр				Гүйлгээний үтгэ Төлбөрийн зориулалт

ГОЛОМТ БАНК 63
ТӨЛБӨР
06.09.2022

Банкинд гүйлгээ хийсэн

Дарга: *[Signature]*
Гамга: ШҮТЭЭН
Ня-бо: *[Signature]*

“Хатуу хучилттай автозам, авто зогсоол, явган жим, нэвтрэх цэгүүд байгуулах төсөл”-ийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөны биелэлтийн тайлан

Хатуу хучилттай автозам, авто зогсоол, явган жим, нэвтрэх цэгүүд байгуулах төслийн талбай дээр ургамалжилтын 9 цэгт бичиглэл хийж дээж авсан.






Ургамлын бичиглэл хийсэн 9 цэгийн зураг

1.5 Гадаргын болон газар доорх ус

2022 оны 8-р сарын 28-нд Хөвсгөл нуурын уснаас /50⁰ 38^I 03.55^{II}, 100⁰ 11^I 49.19^{II}/, Эгийн голын ус /50⁰ 25^I 11.29^{II}, 100⁰ 09^I 04.63^{II}/ дээжнүүд авч “SGS IMME Mongolia” LLC-ний итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэсэн болно.



Усны дээж-1. /Хөвсгөл нуур/



Усны дээж-2. /Эгийн гол/

SGS		SS14CP - 376031	For Lab Use - LIMS No:	
REQUEST FOR LABORATORY SERVICES AND SAMPLE SUBMISSION FORM (MINERALS)				
LABORATORY LOCATION:				
Deliver to:	Attention to:			
CLIENT INFORMATION				
Send Report to:	Send Invoice to (Amounts fee will apply to all submissions)			
Name: <i>Урианхайн</i>	Send to same address as report <input type="checkbox"/>			
Company: <i>Урианхайн Оргойл LLC</i>	Name:			
Mailing Address: <i>578958</i>	Company:			
Project No:		Mailing Address:		
Client Order/PO No:		Email:		
Email: <i>urina.01@gmail.com</i>	Phone: <i>9222100</i>		Fax:	
SAMPLE INFORMATION				
<i>Results and Invoice will be sent by PDF email at no additional charge.</i>				
Send Report: <input type="checkbox"/> OLAB <input type="checkbox"/> Email: <input type="checkbox"/> Other: _____				
<i>Pulps and Residues will be disposed of after 1 month unless requested otherwise in writing. Additional storage and shipping costs will be charged to the client. If the samples are to be returned please provide courier account information</i>				
After analysis samples are to be: Disposed (default) <input type="checkbox"/> Stored <input type="checkbox"/> until (date): _____				
Returned to client <input type="checkbox"/> Return samples using courier: _____ Acct: _____				
IMPORTANT: Please specify Sample Type/Required Quality				
RAB/RC <input type="checkbox"/>	Met Plant <input type="checkbox"/>	Umpire/Party <input type="checkbox"/>	Pulps <input type="checkbox"/>	Soils <input type="checkbox"/> Solutions <input type="checkbox"/> % Core/Rocks <input type="checkbox"/> Other <input checked="" type="checkbox"/>
Please specify Hazards: Concentrates <input type="checkbox"/> Radioactive <input type="checkbox"/> Cyanide <input type="checkbox"/> Arsenic <input type="checkbox"/> Acid <input type="checkbox"/> Contains Asbestos <input type="checkbox"/> High levels Mercury <input type="checkbox"/> Other Hazards <input type="checkbox"/>				SGS Quote#:
Dry at 105°C <input type="checkbox"/>	As received <input type="checkbox"/>	Other (specify) <input type="checkbox"/> _____ °C		Please specify Assay basis (Party/Umpire assays @105°C)
Turnaround Required: Standard <input type="checkbox"/> Premium (contact SGS first; small batches only) <input type="checkbox"/> Other <input type="checkbox"/>				
Special instructions/Sample Matrix: _____				
SAMPLE IDENTIFICATION / ASSAYS REQUIRED				
Sample Preparation Required:		As received, no prep required <input type="checkbox"/> SGS Prep Codes: _____ Other/Special <input type="checkbox"/>		
Sample ID'S	Qty	SGS Analytical Codes	Elements Required	
<i>Thungat amon or Equa 91</i>	<i>2</i>	<i>KP807</i>	<i>Water package</i>	
Total				
Client Authorisation (signature): _____				Date: <i>29 Aug 2022</i>
SAMPLE IDENTIFICATION / ASSAYS REQUIRED				
Sample condition upon receipt:			Received date: _____	
Received by: _____			Logged in date: _____	
<small>TERMS AND CONDITIONS / QUALIFICATIONS AND LIMITATIONS</small>				
<small>All SGS services are rendered in accordance with the applicable SGS Conditions of Service accessible at http://www.sgs.com/terms_and_conditions.htm</small>				

1.6 Хөрсний судалгааны арга зүй

Хөрсний дээжинд морфологи болон зүсэлтийн бичиглэл хийж, лабораторын задлан шинжилгээнд зориулан хөрсний физик, хими шинж чанарын 3 дээж, бохирдол, эвдрэлийн 5 ширхэг дээж авлаа.

Хүснэгт- 4. Хөрсний дээжлэлт

Зүсэлт	Газрын нэр	Уртраг			Өргөрөг		
		Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	Бутлуурын завод, карьер-1.	100	8	45.28	50	25	48.9
2	Хатгал-Хүзүүвчийн шил чиглэлийн 5.5 км авто замын эхлэл	100	10	17.55	50	27	15.64
3	Хатгал-Хүзүүвчийн шил чиглэлийн 5.5 км авто замын дунд	100	9	18.67	50	28	12.93
4	Хатгал-Хүзүүвчийн шил чиглэлийн 5.5 км авто замын төгсгөл	100	9	45.30	50	29	47.52
5	2.2 км авто замын трассын дагуух дээжлэлт	100	8	16.83	50	26	39.55
6	Карьер 2	100	7	02.06	50	31	37.93
7	Кемп-1	100	6	55.97	50	28	46.33
8	Карьер-3	100	11	16.70	50	37	06.19
9	37.9 км замын төгсгөл	100	13	58.33	50	39	02.47



Дээжлэлт-1.



Дээжлэлт-2.



Дээжлэлт-3.



Дээжлэлт-4.



Дээжлэлт-5.



Дээжлэлт-6.



Дээжлэлт-7.



Дээжлэлт-8.





Дээжлэлт-9.

Буртгасан

Сэнгийн сайдын 2017 оны
347 дугаар тухайлын хавсралт

ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ОВАРИМТЛИН

ДЛТД: 60000263600300022082950001196006
 Борлуулгачийн: ТТД: 2635003
 НЭР: ИНЖЕНЕРТӨСӨДЭМ
 Хаяг: Мөнгөл, Улаанбаатар, Баянгол, 6-р хороо, энхтайвны өргөн чөлөө, 1-р дотуур, А кортус
 Утас: 77278800, 77278800, 77278800, 99095839
 Банкны нэр: Төвөр хөгжлийн банк
 Банкны дансны дугаар: 2103001

Огноо: 2022-08-28
 Худалдан авагчийн: ТТД: 5788958
 НЭР: ШҮТЭЭНБАЙГАЛЬ
 Хаяг: Мөнгөл, Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, 5а-26 тоот
 Утас: 99222100

Д/А	Бэрх, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэлхээ нэгж	Тоо, хэмжээ	Нэгжний үнэ	Бүрд үнэ
1	Хөрсний тунд галтосын судалгаа	8342100	ш	1.00	524,700.00	524,700.00
					Бэрх, ажил үйлчилгээний үнэ:	477,000.00
					Нэмэгдсэн өртөмж албан татвар:	47,700.00
					Нийслэл хольц албан татвар:	0.00
					Нийт дүн:	524,700.00

Тэмдэг

Хүлээн авсан: _____ (дарын урсал) _____ (нэр)
 Хүлээлгэн авсан: _____ (дарын урсал) _____ (нэр)

Хөрсний шинжилгээний төлбөрийн баримт

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны бүрдэл хэсгүүд тус бүр дээр хэмжилт, дээжлэлт хийж буй агшныг баталгаажуулсан, төсөл хэрэгжиж буй орчны фонтой хамт авсан гэрэл зураг /цэг бүр дээр 2-оос доошгүй/
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн хээрийн хэмжилт, авсан дээжнүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн эх хувиар
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг баталгаажуулсан гэрэл зураг /арга хэмжээ бүрт 2-оос доошгүй орчны фонтой хамт авсан гэрэл зураг хавсаргах/
- Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн хүрээнд хийсэн ажлыг нотлох гэрэл зураг /гүйцэтгэсэн ажил тус бүрт орчны фоныг оруулан авсан 2-оос доошгүй гэрэл зургийг хавсаргах/
- Тухайн жилийн барилга угсралтын ажлын төлөвлөгөөнд үндэслэн зарцуулсан химийн хортой болон аюултай бодисын ашиглалтын дүн мэдээ
- Аюултай хог хаягдлыг устгах, хадгалах арга хэмжээг хэрхэн гүйцэтгэснийг нотлох гэрэл зураг /арга хэмжээ бүрт орчны фонтой хамт авсан 2-оос доошгүй гэрэл зураг хавсаргах/
- Орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээ, түүний биелэлтийг нотлох баримтууд, гэрэл зургууд
- Эрх бүхий байгууллагуудаас гүйцэтгэсэн ажлыг хүлээж авсан актын хуулбар

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ХУУДАС

Төслийн нэр: Хатуу хучилттай автозам, авто зогсоол, явган жим, нэвтрэх цэгүүд байгуулах төсөл”

Төслийн байршил: Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны нутаг дэвсгэрт

Огноо: 2022 оны 10-р сарын 30

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо							Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар
			Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн 3	Гишүүн 4	Гишүүн 5	Гишүүн 6	Гишүүн 7		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20									
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	30									
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5									
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15									
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	10									
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	10									
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5									
8	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5									
	Нийт оноо	100									

Ажлын хэсгийн дарга: / _____ /

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: / _____ /

Гишүүд:

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч:

/ _____ /

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төлөөлөл: / _____ /

Сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн: / _____ /

Алаг-Эрдэнэ сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч: / _____ /

Алаг-Эрдэнэ сумын байгаль хамгаалагч: / _____ /

Нөлөөллийн бүс дэх иргэдийн төлөөлөл: / _____ /

Алаг-Эрдэнэ сумын газрын даамал: / _____ /

Хүлээн зөвшөөрсөн:

“Бээжин Юни Констракшн Групп Монголиа” ХХК-ийн ерөнхий инженер ...Чингэс